

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2018 оны 8 сарын дугаар

Тэргүүн мэдээ

Улаанбаатар хотод буцалтгүй тусламжаар баригдах сургуулийн барилгын ажил эхлэв.



8-р сарын 24-ний өдөр буцалтгүй тусламжаар хэрэгжих “Улаанбаатар хотын бага дунд сургуулийн барилга байгууламжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 7-р хороонд сургуулийн барилгын шав тавих ёслол болов. Энэ төслөөр 4 сургуулийн барилга барих бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой, байгалийн гамшгийн үед түр хорогдох байр болгон ашиглах боломжтой, байгаль орчинд ээлтэй байх зарчмаар төлөвлөн, бүх хүн хэрэглэхэд хялбар талыг нь харсан зураг төсөл боловсруулсан байна. Энэхүү төсөл нь сургуулийн барилга байгууламжийн хангамжийг сайжруулахад хувь нэмэр оруулахын хамт, цаашид сургуулийн барилгын загвар болно гэдэгт найдаж байна.

Төслийн хэрэгжилт

Хүний нөөцийг хөгжүүлэх (JDS) хөтөлбөрийг төгсөгчдөөс Япон улсын баруун хэсэгт учирсан үерийн гамшигт зориулан хандивын ажиллагаа зохион байгуулав.



8 дугаар сарын 17-ны өдөр Хүний нөөцийг хөгжүүлэх (JDS) хөтөлбөр төгсөгчдийг төлөөлөн Ц.Оюун, Б.Мөнгөнсүх нар ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газарт хүрэлцэн ирж Япон улсын баруун хэсэгт учирсан үерийн гамшигт зориулан 63 төгсөгчдөөс цуглуулсан 170 мянган иений хандивыг Японы Улаан загалмайн нийгэмлэгт шилжүүлсэнээ мэдэгдэв. Ц.Оюун, Б.Мөнгөнсүх нар нь Японы зүүн хэсэгт учирсан томоохон газар хөдлөлтийн дараахь сэргээн босголтын арга хэмжээний газар дээрх судалгаа хийж байсан туршлагатай, нөхцөл байдлыг сайн мэдэх тул энэхүү үйл ажиллагааг зохион байгуулсан хэмээн ярьж байлаа.

“Дархан аймагт амьдралын дадал зуршилтай холбоотой өвчний эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийг сайжруулах төсөл” хэрэгжиж дуусав.



8 дугаар сарын 8-ны өдөр “Өвчний үндэс” ТХА-ны хүрээнд хэрэгжсэн “Дархан-Уул аймагт амьдралын дадал зуршилтай холбоотой өвчний эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийг сайжруулах төсөл”-ийн эцсийн тайлангийн хурал болж Мито Сайсэйкай Нэгдсэн Эмнэлэг (Япон талын гүйцэтгэгч байгуулга), аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллага оролцов. Энэхүү төсөл нь 2015 оноос хэрэгжиж тус аймаг дахь амьдралын дадал зуршилтай холбоотой өвчний талаарх ойлголтыг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, заавар зөвлөгөө өгөх чадавхийг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Төслийн 3 жилийн үйл ажиллааны явцад чихрийн шижинтэй хүмүүст зориулсан хөл арчилгааны булан байгуулах зэрэг арга хэмжээг аймгийн зүгээс санаачлан хэрэгжүүлсэн тул цаашид ч энэ үр дүнгээ хадгалан улам хөгжүүлнэ гэсэн найдлага төрж байна.

Комотек (ХК) компаний тортог шүүгчийг (DPF) Улаанбаатар хотын нийтийн тээврийн 24 автобусанд суурилуулав.



8 дугаар сарын 17-ны өдөр Японы ЖДҮ-ийг гадаадын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх ЖАЙКА-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын нийтийн тээврийн автобусны дизель хөдөлгүүрт DPF (Diesel Particulate Filter) тортог шүүгчийг суурилуулж хөдөлгүүрээс ялгарах тортогжилтыг бууруулах туршилтын төсөл"-өөр Улаанбаатар хотын нийтийн тээврийн 24 автобусанд "Комотек" компаний тортог шүүгчийг суурилуулав. Улаанбаатар хотын агаарын бохирдол хотын тулгамдсан асуудлын нэг болоод байгаа тул хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон оршин суугчид энэхүү төслийн хэрэгжилтийг анхааралтай ажиглаж байгаа бөгөөд ЖАЙКА-ийн лого бүхий 24 автобус үйлчилгээнд явж тортог шүүгчийн үр нөлөөг туршиж байна.

Баруун бүсийн малын эмч нарын зөвлөгөөн дээр мал эмнэлгийн салбарын хоёр төслийн үйл ажиллагааг танилцуулав.



7 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн малын эмч нарын зөвлөгөөн дээр SATREPS "Монгол оронд тохиолддог малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах төсөл" болон ТХА-ны "Мал эмнэлэг, мал аж ахуйн салбарын хүний нөөцийг чадавхжуулах төсөл"-ийн мэргэжилтнүүд төслийн үйл ажиллагааны талаар танилцуулав. Малын эмч нар эгэл биетнээр үүсгэгддэг өвчний эсрэг авах арга хэмжээ, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуулийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл зэрэг дээрх төслүүдийн үр дүнг шимтэн сонсож байсны зэрэгцээ ЖАЙКА-ийн мэргэжилтэнд малаа үзүүлэхээр цугларсан малчид хурлын танхимын гадаа дугаарлан зогсож байсан нь энэхүү хоёр төсөлд ихээхэн найдвар хүлээлгэж буйг харууллаа.

"Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл"-ийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлд (R/D) гарын үсэг зурав.



8 дугаар сарын 22-ны өдөр хөгжлийн төлөвлөгөөний судалгааны ТХА-ны төсөл болох "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл"-ийн Хэлэлцүүлгийн тэмдэглэлд (RD) гарын үсэг зурав. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод хүн ам, үйлдвэрлэлийн хэт төвлөрөл бий болж, улсын хэмжээнд тэнцвэртэй, харилцан уялдаатай хөгжлийн бодлого хэрэгжүүлэх нь нэн тэргүүний зорилт болоод байгаа юм. Энэхүү төслийн хүрээнд улсын хэмжээний цогц хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж, уг төлөвлөгөөнд үндэслэн эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлснээр хот, хөдөө орон нутгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг дэмжин, бүс нутгуудын хоорондын ялгааг арилгаж, Нийслэлийн хотжилтын асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байна.

Бусад төслийн үйл ажиллагаа.

- 8 сарын 13: Ямада Нао (ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар) томилогдон ирэв.
- 8 сарын 20: Фүжита Эри (ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар) томилогдон ирэв.
- 8 сарын 28: Танака Томоаки (ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар) буцав.
- 8 сарын 31: Комикава Норико (ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар) буцав.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын гишүүний танилцуулга

Коосэн мэргэжлийн сургууль дээр мэргэжилтэн бэлтгэхэд оролцож байна.



2014 оны 9 сард үр өгөөжтэй боловсрол, олон талт мэргэжлийн мэдлэг эзэмшсэн техникийн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор Японы коосэн боловсролыг загвар болгож, Монголд 3 коосэн сургууль (Монгол коосэн, ШУТИС-ийн коосэн, Шинэ Монгол коосэн) байгуулагдсан. Япон маягийн “Дарханы урлал” боловсролыг дэлгэрүүлэхэд Монголд тохирсон сургалтын материал хийх, практик сургалт нэн шаардлагатай болоод байна. Иймд ахмад сайн дурын гишүүн Икүсэ Ясүши (механик инженер), Күрокава Ватарү (барилгын инженер) нар нь дээрх 3 коосэн сургуульд томилогдон, сургууль тус бүрийн мэргэжил нэгт багш нартай хамтран сургалтын материал хийж бэлтгэх, практик сургалтын чадавхийг сайжруулах үйлсэд чармайн ажиллаж байна.



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо

Сургалт төгсөгчдийн холбооны 2018 оны санхүүгийн жилд зохион байгуулагдах “Follow up” сургалт семинаруудын сэдэв тодорхой боллоо

Сургалт төгсөгчид Японд хамрагдсан сургалтынхаа үр дүнг танилцуулж, сурсан мэдсэнээ бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Follow up” сургалт семинар зохион байгуулдаг. Семинар зохион байгуулах квот хязгаарлагдмал байдаг хэдий ч жил бүр олон тооны семинарын санал ирдэг тул сургалт төгсөгчдийн холбооны удирдах зөвлөл сонгон шалгаруулалт явуулдаг. 2018 онд 19 семинарын санал хүлээн авсан бөгөөд сонгон шалгаруулалт хийсний үр дүнд “Эх нярайн тусламжийг сайжруулах нь” (эрүүл мэнд), “Бага боловсролын байгалийн ухааны туршилттай хичээл зохион байгуулах арга зүй” (боловсрол), “Олон улсын татвар ногдуулалтын талаар” (татвар), “Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдол, түүнийг бууруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ” (байгаль орчин), “ХАА-н дадал нэвтрүүлэх бодит тогтолцоог Монгол улсын хэмжээнд бүрдүүлэх шаардлага, боломж” (ХАА), “Үйлдвэрт 5S нэвтрүүлэх нь” (5S) сэдэвт сургалт семинаруудыг зохион байгуулахаар боллоо.

Дээрх сургалт семинаруудыг 2018 оны 9 дүгээр сараас ирэх жилийн 1 дүгээр сар хүртэл зохион байгуулахаар төлөвлөж байна.